



## ТОРГОН ХУРДНЫ ЗАМ буюу SILK HIGHWAY

Та бүхэнд MONUK өөрийнхөө хоёрдугаар ажил болох Монгол болон Английн сурган хүмүүжүүлэгчид, урлаг судлаачид, уран бүтээлчдийг оролцуулсан хамтарсан онлайн төслийг танилцуулж байна. Бид анхныхаа ОДОО/CURRENT үзэсгэлэнгээр дамжуулж энэ хоёр орны дунд уран бүтээлч гүүрийг бий болгосон бөгөөд, одоо бид Монголын орчин үеийн урлагийн хөгжилд өөрсдийн байр суурийг бататгахын тулд, бидний холбоо харилцаагаанд саад түвэг болдог орон зай болон хэлний бэрхшээлүүдийг амархан шийдвэрлэж чадах интернэт-дээр суурилсан төслийг явуулахад бэлэн болоод байна.

ОДОО/CURRENT ба ТОРГОН ХУРДНЫ ЗАМ зэрэг нь коммунизмийн дараах ба капитализмийн эхэн үеийн нийгмийн нөхцөл байдлын дунд өөрсдийгөө ойлгуулах гэж зүдэрч байгаа Монголын уран бүтээлчдэд зориулагдсан хамгийн анхны төслүүд юм.

Хэлний үл ойлголцох ханыг эвдэж, ямар нэг маягаар зогсоогдох байтугай асуугдалгүйгээр хил хязгаарыг даван, өөрийн уран сэтгэмжийн нэг хэсгийг гэрлийн хурдаар илгээх зэргүүд нь ТОРГОН ХУРДНЫ ЗАМ-ын цэсийн гол бүрэлдэхүүн юм. Энэ төсөлд Их Британид суурьшдаг уран бүтээлчдийн хувьд аль хэдийн танигдсан боловч Монголын мэргэжил нэгтнүүдэд маань уран бүтээл хийх арга мэтээр өргөн хэрэглэгддэггүй хэрэгслүүдийг ашиглах болно. Тухайн төсөл маань эцсийн дууссан бүтээгдэхүүнийг голчлохоосоо илүү уран бүтээл бий болох явцад анхаарлаа хандуулах бөгөөд энэ нь харилцаа холбоог үгс, перформанс, видео болон дүрслэлийн тусламжтайгаар дараагийн шатанд аваачих зорилготой.

ТОРГОН ХУРДНЫ ЗАМ нь мөн Ази Европ хоёрыг холбосон алдарт Торгоны Замыг билэгдсэн орчин үеийн нэрлэл ба, энэ сэдвийг одоог хүртэл олон судлаачдын сонирхон судладаг бөгөөд, энэ нэр нь олон янзын байдлаар ашиглагддаг. Гэвч уран бүтээлчид төсөлд оролцохдоо Торгоны замтай бүтээлээ заавал холбох шаардлагагүй ба өөрсдийн хүсэлтээр түүнээс санаа авах нь хувийн сонголтын асуудал юм.

Бид Google хайх системийн зохиосон маш энгийн Blogger нэртэй веб сайтыг ашиглах бөгөөд, энэ веб сайт нь ТОРГОН ХУРДНЫ ЗАМ-ын үгсийн болон дүрслэлийн солилцоо явагдах онлайн урлан болно. Төсөл үүний хажуугаар уран бүтээлчдийн хоорондын ойлголцол болон оролцоог идэвхжүүлэхийн тулд Англи болон Монгол хэлээр сэтгүүл гаргахыг зорьж байгаа болно. Энэ төсөл нь давтагдмал биш, тогтсон хэм хэмжээг ба хязгаарыг даван туулах дуртай, үл ойлгогдох болон үл мэдэгдэх хүчин зүйлүүдээр өөрийгөө сорих хүсэлтэй хүмүүсийн сонирхлыг татах болно.

Та үүнээс болж замаа алдаж магад, тэгээд бүр эргэлзээнд орж ч мэднэ, гэхдээ таныг замаа дахин олоход тэр бүхэн тусална.

Цэгмидийн Цэндпүрэв

MONUK Төслийн Удирдагч  
Докторант

Орчин Үеийн Урлагийн Ухааны Магистр  
Лийдс Метрополитений Их Сургууль, Их Британи Улс

Төслийн анхан шатны Англид суурьшдаг уран бүтээлчдийн бүртгэл явагдсан бөгөөд Монголын уран бүтээлчдийг сонгон шалгаруулах эцсийн хугацаа 2008.9.30-нд дуусгавар болно. Төсөлд оролцох хүсэлтэй Монголын сурган хүмүүжүүлэгчид, урлаг судлаачид, уран бүтээлчдийг холбоо барьж төслийн өргөдлийн маягтыг цаасан болон электрон хэлбэрээр хүлээн авахыг урьж байна. Өргөдлийн маягтыг электрон хэлбэрээр хүлээн авах хүмүүс өөрийн флаш/usb stick-ээ авчирна уу. Бүртгэлийн хураамж үнэгүй бөгөөд сонгогдсон уран бүтээлчид төсөлд оролцохын тулд ямар нэг нэмэлт төлбөр хийх шаардлагагүй.

[www.silkhighway.blogspot.com](http://www.silkhighway.blogspot.com)

Холбоо барих утас : 95206306, Емэйл: TSTSendee@yahoo.com

# SILK HIGHWAY/ТОРГОН ХУРДНЫ ЗАМ

Өргөдлийн журам болон анхаарах зүйлсийн тэмдэглэл

---

Та энэ журмыг сайтар уншиж танилцаад дараа нь өөрийн өргөдлийн маягтыг бөглөнө үү

## Төсөл

ТОРГОН ХУРДНЫ ЗАМ нь онлайн төсөл бөгөөд таны тогтвортой оролцоо маш чухал. Төсөл таныг интернет-ийн сүлжээнд орох боломжтой байхыг шаардана. ТОРГОН ХУРДНЫ ЗАМ –ын харилцааны үе нь ойролцоогоор 8 долоо хоногийн хугацаанд явагдах ба та өөрийн емэйлд хамгийн багаар бодоход 7 хоногт 2 удаа хариулах үүрэгтэй байх болно. Төсөл таныг их Британи улсад суурьшдаг уран бүтээлчтэй холбох бөгөөд, та хоёрын хоорондын харилцааг төсөл өөрөө санхүүжүүлэн үнэ төлбөргүй орчуулж өгнө.

## Шалгаруулалт

Хэрвээ та төсөлд оролцохоор шалгарвал, та төслийн дундаас гарах боломжгүй. Гэхдээ төсөл маш хүнд шалтгааныг харгалзан авч үзнэ. ТОРГОН ХУРДНЫ ЗАМ нь шууд явагдах хамтарсан онлайн төсөл бөгөөд оролцогч уран бүтээлчдийг урьдчилан бэлтгэсэн санаа агуулахгүйгээр, өөрийн одоо хийж байгаа уран бүтээлийн үргэлжлэл маягаар хандахгүйгээр, энэ төслийг шинэ сэргэг боломж мэтээр хүлээж авахыг хүсэж байгаа болно. Оролцогч төслийн үр дүнд эцсийн бүтээгдэхүүн буюу дууссан уран бүтээл хийх шаардлагагүй ба, гэхдээ оролцогч нь өөрийн сэтгэгдлийн тухай бичих хэрэгтэй болно. Мөн оролцогч төслийн сэтгүүлд хувь нэмрээ оруулна.

## Төслийн санхүүжилт

Төсөл нь өөрийн гэсэн тогтсон санхүүжүүлэлтгүй боловч Их Британи Улсын Лийдс Метрополитений Их Сургуулиас байр болон техникийн бага хэмжээний туслалцаа авдаг болно. Төсөл шалгарсан уран бүтээлчдэд ямар нэг санхүүгийн тусламж үзүүлэх боломжгүй. Гэхдээ төсөлд оролцсоноороо та өөрийн нэр болон уран бүтээлийг Их Британид суурьшдаг мэргэжил нэгтнүүддээ таниулахаас гадна, MONUK ашгийн бус урлагийн байгууллагаас зохион байгуулах цааш цаашдын арга хэмжээнд оролцох үүд хаалга нээгдэж байгаа билээ. Таны уран бүтээлийг төсөл дууссанаас хойш өөрийн веб хуудас болон сэтгүүл дээр байнга өргөнөөр сурталчлах болно.

## Зохиогчийн эрхийн асуудал

Та өөрийн бүтээлийн зохиогчийн эрхийг бүрэн хадгалах ба энэ төслийн үр дүнд бий болсон уран бүтээлдээ та хамтарсан уран бүтээлчийн нэрийг дурдах хууль ёсны хариуцлага хүлээнэ. Төсөл таны нэр болон бүтээлийг сурталчилгаа болон сэтгүүл дээр ашиглах болон хэвлэх эрхийг хадгалах бөгөөд, ингэхийг тулд танаас зөвшөөрөл авах шаардлагагүй.

## Төслийн өргөдлийг хүлээн авах эцсийн хугацаа

Төслийн анхан шатны Англид суурьшдаг уран бүтээлчдийн бүртгэл явагдсан бөгөөд Монголын уран бүтээлчдийг сонгон шалгаруулах эцсийн хугацаа 2008.9.30-нд дуусгавар болно.

Төсөлд оролцох хүсэлтэй Монголын сурган хүмүүжүүлэгчид, урлаг судлаачид, уран бүтээлчдийг холбоо барьж төслийн өргөдлийн маягтыг цаасан болон электрон хэлбэрээр хүлээн авахыг урьж байна. Өргөдлийн маягтыг цаасан болон электрон хэлбэрээр хүлээн авах хүмүүс өөрийн флаш/usb stick-ээ авчирна уу.

Бүртгэлийн хураамж үнэгүй бөгөөд сонгогдсон уран бүтээлчид төсөлд оролцохын тулд ямар нэг нэмэлт төлбөр хийх шаардлагагүй.

Веб хаяг <http://silkhighway.blogspot.com/>

Холбоо барих утас : 95206306

Емэйл: TSTSendee@yahoo.com

## **SILK HIGHWAY/ТОРГОН ХУРДНЫ ЗАМ**

### **Өргөдлийн маягт**

---

Та энэ төслийн журмыг сайтар уншиж танилцаад дараа нь өөрийн өргөдлийн маягтыг бөглөнө үү

Би энэхүү өргөдлийн маягтыг бөглөснөөрөө ТОРГОН ХУРДНЫ ЗАМ төслийн журмыг хүлээн зөвшөөрснөө илэрхийлж байна.

Оролцогчийн тухай мэдээлэл

Нэр овог:

Гэрийн хаяг:

Веб хуудас:

Емэйл:

Утасны дугаар:

### **1. Таны уран бүтээл болон дадлагын тухай**

Та өөрийн сүүлийн үеийн уран бүтээл болон бүтээлийн чиг хандлагын тухай товч танилцуулна уу. Үгийн дээд хэмжээ 500. Хэрвээ та төсөлд оролцохоор шалгарвал дээрх мэдээлэл таныг төслийн веб хуудас, зар сурталчилгаа болон сэтгүүлд ашиглах болно.

## **2. ТОРГОН ХУРДНЫ ЗАМ төсөл**

ТОРГОН ХУРДНЫ ЗАМ нь шууд явагдах хамтарсан онлайн төсөл бөгөөд оролцогч уран бүтээлчдийг урьдчилан бэлтгэсэн санаа агуулахгүйгээр, өөрийн одоо хийж байгаа уран бүтээлийн үргэлжлэл маягаар хандахгүйгээр, энэ төслийг шинэ сэргэг боломж мэтээр хүлээж авахыг хүсэж байгаа болно. Оролцогч төслийн үр дүнд эцсийн бүтээгдэхүүн буюу дууссан уран бүтээл хийх шаардлагагүй ба, гэхдээ оролцогч нь өөрийн сэтгэгдлийн тухай бичих хэрэгтэй болно. Мөн оролцогч төслийн сэтгүүлд хувь нэмрээ оруулна.

Та төслийн сэдэв буюу ТОРГОН ХУРДНЫ ЗАМ-ын тухай сэтгэгдлээ бичнэ үү. Та энэ сэдвийн дагуу ямар уран бүтээл хийх бодолтой байгаа болон онлайн-аар нөгөө талын уран бүтээлчидтэй яаж харилцан хамтарч ажиллах санаатай тухайгаа бичнэ үү. Үгийн дээд хэмжээ 500.

### 3. Өргөдөлд хавсрах материалууд

Та сүүлийн уран бүтээлээсээ 5-ыг хавсаргана уу. Бүх төрлийн бүтээл байж болох ба видео болон перформанс ажлийн фото зураг байж болно. Та файл-аа 1mb хэмжээнээс багагүй 150 dpi чанартайгаар бэлдэнэ үү.

НЭР	ОН	ЯМАР ТӨРӨЛ
1.		
2.		
3.		
4.		
5.		

Та доорх шаардагдах материалуудыг хангаснаа шалгана уу.

1. Бөглөсөн өргөдлийн маягт
2. Хавсрах материалууд
3. Үзэсгэлэн болон төсөлд оролцсон жагсаалт

Гарын үсэг \_\_\_\_\_ Он сар өдөр \_\_\_\_\_

### Өргөдөл хүлээн авах эцсийн хугацаа

Төслийн анхан шатны Англид суурьшдаг уран бүтээлчдийн бүртгэл явагдсан бөгөөд Монголын уран бүтээлчдийг сонгон шалгаруулах эцсийн хугацаа 2008.9.30-нд дуусгавар болно.

Төсөлд оролцох хүсэлтэй Монголын сурган хүмүүжүүлэгчид, урлаг судлаачид, уран бүтээлчдийг холбоо барьж төслийн өргөдлийн маягыг цаасан болон электрон хэлбэрээр хүлээн авахыг урьж байна. Өргөдлийн маягыг цаасан болон электрон хэлбэрээр хүлээн авах хүмүүс өөрийн флаш/usb stick-ээ авчирна уу.

Бүртгэлийн хураамж үнэгүй бөгөөд сонгогдсон уран бүтээлчид төсөлд оролцохын тулд ямар нэг нэмэлт төлбөр хийх шаардлагагүй.

Веб хаяг: [www.silkhighway.blogspot.com/](http://www.silkhighway.blogspot.com/)

Холбоо барих утас : 976- 95206306

Емэйл: TSTSendee@yahoo.com